



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 5/18

Ховд


Г Д.Отгонтуяаг ажилд томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 05/5937 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Дамиржавын Отгонтуяаг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн “Мянган угалзат” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын даргаар томилсугай.

2. Д.Отгонтуяад Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТҮ-9-2 дахь шатлал буюу 791127 төгрөг /долоон зуун ерөн нэгэн мянга нэг зуун хорин долоо/-өөр цалинжуулахыг нягтлан бодогч /Т.Цэвээнням/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ